



МОНГОЛ УС
ТОВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАЛЖ

2019 оны 04 сарын 15-рдээр

Дугаар A/628

Зуунмод

Газрын хэмжээг өөрчилж,
газар эзэмших эрхийг баталгаажуулах
тухай

Монгол Улсын Засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Зуунмод сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 2.1.5-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Раднаасэд овогтой Болдын Зуунмод сумын 1-р баг, Жаргалан хотхон, Рашааны гудамж 308 тоотод ахуйн зориулалтаар эзэмшиж буй газрын объект баригдсан газар нь хяналтын хэмжилтээр 496 м² байгаа тул 298 м² газрын суурь үнийг төлүүлэн эзэмшүүлж, газрын хэмжээг 496 м² болгон өөрчилсүгэй.

2. Газар эзэмшигч иргэн Р.Болд дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын толбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.4. Одоо объект баригдаж, хашаажсан илүү гарсан 298 м² газрыг суурь үнэ 1м²=1600 төгрөгөөр тооцож 473,600 /Дөрвөн зуун далан гурван мянга зургаан зуун/ төгрөгийг бүрэн толох.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Огтонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/680 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

61 000591